

**ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-95-ЫН ХАРЬЦУУЛАЛТ**

<p align="center"><b>Хэрэглэлийн нислэгийн журмын бүртгэл</b> (Шинэчлэгдэж байгаа) /7 хуудас/ 2010 оны NZ amend.1</p>	<p align="center"><b>ХЭРЭГЛЭЛИЙН НИСЛЭГИЙН ДҮРМЭЭР БУУЛТЫН ОЙРТОЛТ ҮЙЛДЭХ БА САНСРЫН НАВИГАЦИ АШИГЛАХ</b> (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /6 хуудас (үндсэн дүрэм- 30 хуудастай байсан)</p>	<p align="center"><b>Тайлбар</b></p>
<p><b>А Бүлэг — Ерөнхий зүйл</b></p>	<p><b>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ/ GENERAL</b></p>	
<p><b><u>95.1. Зорилго</u></b> <u>Энэ Дүрэм нь Монгол Улсын нислэгийн мэдээллийн бүсэд FIR-аар үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт ашиглах хэрэглэлийн нислэгийн журмыг зарлан мэдэгдэх зохицуулалтын шаардлагыг тогтооно.</u></p>	<p><b>95.1. Зорилго</b> <b>(а) <u>Хэрэглэлийн нислэгийн дүрмээр буултын ойртолт үйлдэх болон сансрын навигаци ашиглах журмыг тогтооход дүрмийн зорилго оршино.</u></b></p>	<p>-Зорилго өөрчлөгдсөн, “сансрын навигаци ашиглах” зохицуулалтууд нь ИНД-19-д тусгагдсан</p>
<p><b><u>В Бүлэг - Хэрэглэлийн нислэгийн журмыг зарлан мэдэгдэх болон мэдээлэх</u></b></p>	<p><b><u>Б БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛИЙН НИСЛЭГИЙН ДҮРЭМ- САНСРЫН НАВИГАЦИЙН СИСТЕМ</u></b></p>	<p>-Бүлгийн зохицуулалт өөрчлөгдсөн</p>
<p><b><u>95.51. Хэрэглэлийн нислэгийн журмыг зарлан мэдэгдэх</u></b> <u>Аливаа этгээд нь Монгол Улсын FIR-д, IFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт ашиглах хэрэглэлийн нислэгийн журмыг дараахаас бусад тохиолдолд зарлан мэдэгдэхгүй:</u> <u>(1) тухайн хэрэглэлийн нислэгийн журмын дэлгэрэнгүй мэдээллийг Монгол Улсын Агаарын навигацийн бүртгэлд (ANR) энэ Дүрмийн дагуу оруулсан байх;</u> <u>(2) тухайн Хэрэглэлийн нислэгийн журмын хүчинтэй болох огноо нь 95.55-ын дагуу www.mcaa.gov.mn цахим хуудсанд мэдээлсэн байх.</u></p>	<p><b><u>95.51. Ерөнхий зүйл</u></b> <b>(а) Энэ бүлгээр сансрын навигацийн системийг ХНД-ээр үйлдэх нислэгт ашиглахад тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох бөгөөд энэ нь иргэний нисэхийн бусад дүрэмд нэмэлт заалт болно.</b></p>	<p>Монгол Улсын Нислэгийн мэдээллийн район (FIR), Монгол Улсын Агаарын навигацийн бүртгэл (ANR) гэсэн ойлголтууд нэмэгдсэн</p>
<p><b><u>95.53. Монгол Улсын ANR-д дэлгэрэнгүй мэдээлэл оруулах</u></b> <b>(а) Энэ зүйлийн (b)-г харгалзан, Дарга Монгол Улсын FIR-д, IFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт ашиглахад зориулсан хэрэглэлийн нислэгийн журам бүрийн дараах дэлгэрэнгүй мэдээллийг Монгол Улсын ANR-д оруулах үүрэгтэй:</b> <b>(1) тухайн хэрэглэлийн нислэгийн журмын нэр, эсхүл бусад холбогдох таних нэр томъёо;</b> <b>(2) тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг тодорхойлох болон тайлбарлах нисэхийн өгөгдөл;</b> <b>(3) тухайн хэрэглэлийн нислэгийн журам хүчинтэй болох огноо;</b> <b>(4) энэ зүйлийн (b)(1)-д шаардсан хэрэглэлийн нислэгийн журмыг батлах үүрэг хариуцлага хүлээсэн хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчийн тодорхойлолт;</b></p>	<p><b><u>95.53. Тодорхойлолт ба товчлол</u></b> <b><u>"GPS"- сансрын навигацийн байрлал тодорхойлох систем;</u></b> <b><u>"GLONASS" – Оросын холбооны улсын сансрын навигацийн систем;</u></b> <b><u>"GNSS" – сансрын навигацийн систем;</u></b> <b><u>"GPS дамжуулагч" - NANU, NAVSTAR рүү мэдээлэл дамжуулагч (GPS NOTAM);</u></b> <b><u>"GPS үндсэн мэдээлэл" гэж нисэх буудлын байрлалын мэдээллүүд, газрын тоног төхөөрөмж, илтгэх цэг, гаралтын стандарт схем, нисэн ирэх стандарт схем, хэрэглэлийн тусламжтайгаар үйлдэх бүүх-ойртолт, тусгай агаар мандлын бүс болон нисгэгчид шаардлагатай бусад мэдээллийг агуулсан санамжийн электрон байгууламжийг;</u></b> <b><u>"Навигацийн анхдагч систем" гэж нарийвчлал болон системийн хэвийн ажиллагааг мэдээлэх шаардлагыг нислэгийн үе шатанд хангасан боловч бэлэн байдал, үйлчилгээний тасралтгүй байдлын шаардлагыг гүйцэд хангаагүй байж болох навигацийн системийг;</u></b> <b><u>"Навигацийн туслах систем" гэж навигацийн үндсэн системтэй холбоотой ажиллах навигацийн системийг тус тус хэлнэ.</u></b></p>	<p>-Энэ зүйл нь Шинэ-Зеландын Part-95-ын төсөлд байсан бөгөөд 2008 онд батлагдсан Part-95-д энэ зүйл тусаагүй</p>

<p>(5) <u>энэ зүйлийн (b)(2)-т шаардсан, хэрэглэлийн нислэгийн журмын засвар өөрчлөлт хийх үүрэг хариуцлага бүхий хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчийн тодорхойлолт.</u></p> <p>(b) <u>Хэрэглэлийн нислэгийн журмыг тогтоож байгаа нисэхийн өгөгдлийг Монгол Улсын ANR-д оруулахын өмнө Дарга дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:</u></p> <p>(1) <u>тухайн хэрэглэлийн нислэгийн журам нь ИНД-173-ын холбогдох шаардлага болон стандартыг хангасан бөгөөд ИНД-173-ын дагуу олгосон хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний холбогдох хүчинтэй гэрчилгээ эзэмшигчээр зохих ёсоор зөвшөөрөгдсөн этгээд баталсан байх;</u></p> <p>(2) <u>тухайн хэрэглэлийн нислэгийн журамд ИНД-173.63-д шаардсан гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны журмын дагуу засвар өөрчлөлт хийсэн бөгөөд энэ хэсгийн (1)-д заасан холбогдох хүчинтэй хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчийг төлөөлж байгаа этгээд баталсан байх;</u></p> <p>(3) <u>энэ зүйлийн (a)-д шаардсан нисэхийн өгөгдлийн ажиллагаа, эсхүл боловсруулалт болон мэдээлэл оруулах, сэргээх, эсхүл хадгалах явцад, RTCA Inc-ийн document number RTCA/DO-200A-д заасан ажиллагаа, эсхүл боловсруулалтын стандартыг, эсхүл Даргын хүлээн зөвшөөрсөн дүйцэх бусад стандартыг хангадаг байх.</u></p> <p>(c) <u>Дарга, хэрэглэлийн нислэгийн журамтай холбоотой нисэхийн өгөгдлийг Монгол Улсын ANR-д оруулах, эсхүл гаргах аливаа хөдөлгөөн нь Нисэхийн мэдээлэл дамжуулах стандарт загвар-5-д (AIXM-5) заасан стандарт, эсхүл Даргын хүлээн зөвшөөрсөн бусад дүйцэх стандартыг хангаж байгааг бататгах үүрэгтэй.</u></p>	<p><u>"Навигацийн үндсэн систем" гэж навигацийн системийн гол үзүүлэлтүүд болох нарийвчлал, системийн хэвийн ажиллагааг мэдээлэх чадвар, бэлэн байдал, үйлчилгээний тасралтгүй ажиллагааг нислэгийн үе шатанд бүрэн хангасан навигацийн системийг;</u></p> <p><u>"Хүлээн авагчийн бие даасан, иж бүрэн хяналт (RAIM)" гэж нислэгийн тухайн үе шатанд GPS-ийн хүлээн авагчийн боловсруулсан байрлал тодорхойлох мэдээллийн алдаа болон системийн хэвийн ажиллагааг мэдээлэх, техникийн стандартаар хянан гэрлэн ба дуут дохио өгөхийг;</u></p> <p><u>"RAIM дохиолол " гэж GPS-ийн хиймэл дагуулуудаас ирж байгаа мэдээлэл нь байрлалын навигацийн шаардлагыг бүрэн хангахгүй байж болзошгүйг анхааруулсан дохиог;</u></p>	
<p><b>95.55. Олон нийтэд мэдээлэх</b></p> <p>(a) <u>IFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт ашиглах хэрэглэлийн нислэгийн журам нь дараахаас бусад тохиолдолд хүчинтэй болохгүй:</u></p> <p>(1) <u>тухайн хэрэглэлийн нислэгийн журмын дэлгэрэнгүй мэдээллийг 95.53-ын дагуу Монгол Улсын ANR-д оруулсан байх;</u></p> <p>(2) <u>энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд,</u></p>	<p><b>95.55. Нисгэгчийн бэлтгэл</b></p> <p>(a) <u>Шалгалтын нислэгт GPS хүлээн авагч болон Нислэг удирдлагын систем (FMS) ашиглан GPS хэрэглэлийн тусламжтайгаар буултын ойртолт үйлдэх үр чадвараа шалгуулж, энэ тухай нислэгийн дэвтэртээ шалгах нисгэгчээр тэмдэглүүлээгүй агаарын хөлгийн дарга GPS хүлээн авагч ашиглан ХНД-ээр буултын ойртолт үйлдэхийг хориглоно.</u></p>	<p>-Энэ зүйлийн зохицуулалт ИНД-19-д тусгагдсан</p>

<p><a href="http://www.mcaa.gov.mn">Дарга дараах мэдээллийг: www.mcaa.gov.mn</a> <a href="#">цахим хуудсанд мэдээлсэн байх:</a></p> <p>(i) <a href="#">тухайн хэрэглэлийн нислэгийн журмын нэр, эсхүл холбогдох бусад таних нэр томъёо;</a></p> <p>(ii) <a href="#">IFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт ашиглах хэрэглэлийн нислэгийн журмын хүчинтэй болох огноо.</a></p> <p>(b) <a href="#">6 сар, эсхүл түүнээс бага хугацаагаар хүчинтэй байх хэрэглэлийн нислэгийн журмыг, хэрэв энэ зүйлийн (a)(2)-т шаардсан мэдээлэл нь Монгол Улсын AIP-ын нэмэлт хавсралтаар, эсхүл NOTAM-аар зарлагдсан бол <a href="http://www.mcaa.gov.mn">www.mcaa.gov.mn</a> цахим хуудсанд мэдээлэхийг шаардахгүй.</a></p>	<p><a href="#">(б) Шалгах нисгэгч нь, GPS хүлээн авагч болон Нислэг удирдлагын систем (FMS) ашиглах үр чадвараа шалгалтын нислэгт харуулж, холбогдох шаардлагыг хангасан нисгэгчийн нислэгийн дэвтэрт дээрх системүүдийг ашиглаж нислэг үйлдэхийг зөвшөөрсөн тэмдэглэл хийж баталгаажуулсан байна.</a></p>	
<p><b><a href="#">95.57. Хэрэглэлийн нислэгийн журмыг хэрэглээнээс хураах</a></b></p> <p>(a) ИНД-173-ын дагуу олгосон хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээ эзэмшигч нь Монгол Улсын ANR-д орсон хэрэглэлийн нислэгийн журмын засвар өөрчлөлт хийхийг цаашид зогсоохоор төлөвлөж байгааг мэдэгдсэн бол Дарга тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг дараах хэлбэрээр хэрэглээнээс хурааж авах үүрэгтэй:</p> <p>(1) хэрэглэлийн нислэгийн журмыг таньж тогтоон, тухайн журмыг хэрэглээнээс хураах огноог <a href="http://www.mcaa.gov.mn">www.mcaa.gov.mn</a> <a href="#">цахим хуудсанд</a> мэдээлэх;</p> <p>(2) тухайн хураан авсан өдөр Монгол Улсын ANR-аас хэрэглэлийн нислэгийн журмын дэлгэрэнгүй мэдээллийг гаргах.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасныг үл харгалзан, хэрэв Дарга дараах бодит үндэслэл байгаа бол тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг хамгийн тохиромжтой хэлбэрээр хэрэглээнээс хураан авч болно:</p> <p>(1) хэрэглэлийн нислэгийн журмыг IFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт ашиглахад аюултай байж болох; эсхүл</p>	<p><b><a href="#">95.57. GPS-ийг анхдагч хэрэглэлээр ашиглах</a></b></p> <p><a href="#">(а) ХНД-ээр GPS-ийг анхдагч хэрэглэлээр ашиглаж байгаа аливаа этгээд нь:</a></p> <p><a href="#">1/ дараах зүйлийг бататгана:</a></p> <p><a href="#">1.1 GPS хэрэглэл нь ИНЕГ-аар хүлээн зөвшөөрөгдсөн эсэх;</a></p> <p><a href="#">1.2 тухайн GPS-ийг навигацийн анхдагч хэрэглэлээр ашиглахыг ИНЕГ-аас зөвшөөрсөн эсэх.</a></p> <p><a href="#">2/ тухайн GPS-ийг тухайн агаарын хөлгийн Нислэгийн ашиглалтын заавар ба түүний хавсралтад заасны дагуу ажиллуулна,</a></p> <p><a href="#">3/ Монгол Улсын нислэгийн мэдээллийн районд үйл ажиллагаа явуулж байгаа агаарын хөлгийн хувьд дараах зүйлийг бататгана:</a></p> <p><a href="#">3.1 хэрэв агаарын тээвэрлэлт үйлдэж байгаа бол, GPS хүлээн авагчаас гадна бие даасан 2-оос доошгүй навигацийн системээр тоноглогдсон байх;</a></p> <p><a href="#">3.2 хэрэв агаарын тээвэрлэлтээс бусад тээвэрлэлтийн нислэг үйлдэж байгаа бол, GPS хүлээн авагчаас гадна бие даасан 1-ээс доошгүй навигацийн системээр тоноглогдсон байх.</a></p> <p><a href="#">4/ хэрэв GPS-ийн суурь мэдээг ашиглан буултын ойртолт үйлдэхээр төлөвлөсөн бол нисэн гарахаасаа очих хүртэлх тооцоот хугацааны RAIM-ийн тооцоог:</a></p> <p><a href="#">4.1 агаарын хөлгийн GPS хүлээн авагчийг ашиглан хийнэ; эсхүл</a></p> <p><a href="#">4.2 ИНД-172-ын дагуу гэрчилгээжсэн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагаас авна.</a></p> <p><a href="#">5/ аэродром орчмын болон чиглэлийн нислэгийн навигацид дараах зүйлийг бататгана:</a></p> <p><a href="#">5.1 нислэг үйлдэх тухайн чиглэл болон бүсийн зурагт нийцсэн GPS-ийн суурь мэдээ, ашиглах; ба</a></p> <p><a href="#">5.2 чиглэлийн болон бүсийн зураг дээрх илтгэх цэгүүдийн</a></p>	<p>-Энэ зүйлийн зохицуулалт ИНД-19-д тусгагдсан</p>

(2) хэрэглэлийн нислэгийн журамд ИНД-173-ын холбогдох шаардлагын дагуу засвар өөрчлөлт хийгээгүй.

(с) Хэрэв Дарга энэ зүйлийн (а), эсхүл (b)-ийн дагуу хэрэглэлийн нислэгийн журмыг хэрэглээнээс хураан авах бол Дарга дараах үүрэгтэй:

(1) тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг хураан авч байгааг, Монгол Улсын ANR-д заасан, хэрэглэлийн нислэгийн журмын засвар өөрчлөлт хийх үүрэг хариуцлага хүлээсэн хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчид бичгээр мэдэгдэх;

(2) тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг Монгол Улсын AIP-аас болон үйл ажиллагааны хэрэглээнээс хассан болохыг бататгах зохих арга хэмжээг авах;

(3) тухайн хэрэглэлийн нислэгийн журам болон түүнтэй холбоотой нисэхийн өгөгдлийг Монгол Улсын ANR-аас хасах.

хоорондох зай ба чиглэлээр GPS-ийн суурь мэдээ тус бүрийг зохих нарийвчлалтай харьцуулан шалгах.

6/ GPS-ийн суурь мэдээг ашиглан үйлдэгдэх бүх ойртолт нь батлагдсан хүчин төгөлдөр журам, ойртолтын зургийн дагуу гүйцэтгэгдэнэ гэдгийг бататгана.

7/ хэрэв чиглэлийн нислэгийн үе шатанд “RAIM дохиолол” 10 минутаас дээш хугацаанд, эсхүл GPS хэрэглэлийн ажиллагаа DR горимд нэг минутаас дээш хугацаанд ажиллавал:

7.1 холбогдох нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанд илтгэнэ;

7.2 ХНД-ээр зөвшөөрөгдсөн навигацийн өөр систем ашиглан агаарын хөлгийн байрлалыг 10 минут тутамд шалгана.

8/ RAIM дохиолол ажилласан үед хэрэглэлийн тусламжтайгаар буултын ойртолт үйлдэж болохгүй.

9/ хэрэв ИНД-91-ийн дагуу бэлтгэл аэродром ашиглах бол дараах зүйлийг бататгана:

9.1 бэлтгэл аэродром нь хэрэглэлийн тусламжтайгаар буултын ойртолт үйлдэх батлагдсан журам бүхий GPS-ээс өөр, радио навигацийн бүрэн ажиллагаатай системтэй эсэхийг.

9.2 агаарын хөлөг нь энэ хэсгийн 9.1-д дурьдсан радио навигацийн төхөөрөмжийг ашиглах навигацийн хэрэглэлээр тоноглогдсон эсэхийг.

Дүрмийн боловсруулалтын хэлтэс